# Монгол Улс
# Зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээ (цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээ) болон зудыг тэсвэрлэх чадавхыг бүрэлдүүлэх төслийн мэдээлэл цуглуулах судалгааны ажил

2022 оны 10-р сарын 3 өдөр

Ориэнтал Консалтанц Глобал ХК

## Судалгааны зорилго ба агуулга

| | |
|---|---|
| **Ажлын нэр** | Монгол Улсын зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээ (цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээ) болон зудыг тэсвэрлэх чадавхыг бүрэлдүүлэх төслийн мэдээлэл цуглуулах судалгааны ажил |
| **Хариуцаж буй газар хэлтэс** | Зүүн болон Төв Азийн газрын Зүүн Азийн хэлтэс |
| **Хугацаа (урьдчилсан байдлаар)** | 2022 оны 9-р сарын 29 өдөр～2023 оны 1-р сарын 16 өдөр |

【Судалгааны зорилго】

Уг судалгаагааны хүрээнд Монгол Улсад зудын хор уршгийн талаарх нөхцөл байдал, тулгарч буй асуудалд шинжилгээ хийж, зудаас урьдчилсан сэргийлэх чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн төсөл боловсруулах талаар судална. Тухайлбал, хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх үүднээс ЖАЙКА-ийн хамтын ажиллагааны төсөл хэрэгжүүлэх боломж ба уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бодлого арга хэмжээний хүрээнд санхүүжилт (Green Climate Fund сан гэх мэт) авах талаар судалж үзнэ.

【Судалгааны хамрах хүрээ】

① Өмнөх судалгааны үр дүнд боловсруулсан төслийн шийдвэрлэх асуудлууд, үр дүн болон тогтвортой байдлын талаар дэвшүүлсэн саналыг нягталж,

② Зудын гамшгаас хамгаалах арга хэмжээ болон гамшигт тэсвэрлэх чадавхыг бүрэлдүүлэх (тухайлбал, зудын хор уршгаас урьдчилан сэргийлэх, зайлсхийх, бууруулах бөгөөд цаашид "гамшгаас хамгаалах, дасан зохицох" гэх)-эд чиглэсэн малчдын аж ахуй дахь шинэчлэлтийг нэвтрүүлж, бодит үр өгөөж бий болгохын тулд үйл ажиллагааны чиглэлийг судалж,

③ Төсөл хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт болон дэд бүтэц гэх зэрэг төсөл хэрэгжүүлэх нөхцөл боломжийг судлахад шаардлагатай мэдээллийг цуглуулна.

## Concept Note-д тусгагдах үйл ажиллагаа ба судалгааны агуулга

### Concept Note-д тусгах үйл ажиллагаа

① Зудын эрсдэлийн мэдээний нарийвчлалыг сайжруулж, түүний ашиглалтын чадавхыг бэхжүүлэх

② Зудын эрсдэлийн мэдээг үр дүнтэй ашиглах

③ Нарны эрчим хүч ашигласан махны хөргүүрийн систем (нарны эрчим хүчний систем) нэвтрүүлэх

④ Хүнсний аюулгүй байдлыг хангасан малын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл ба нийлүүлэлтийг сайжруулах

### Судалгааны агуулга

(① ②) Малчдын зуданд дасан зохицох чадавхыг сайжруулахад чиглэсэн мэдлэг, дадал зуршлын талаар судлах
① Малчдын МАА-н өнөөгийн байдал ба тулгарч буй асуудал
② Зудын урьдчилсан мэдээг хүлээн авч хэрэгжүүлдэг гамшгаас хамгаалах арга хэмжээ, түүний мэдлэг
③ Мэдээлэл хүлээн авах болох илгээх хэрэгсэл
④ ЗГ болон орон нутгийн засаг захиргаанаас малчдад үзүүлдэг дэмжлэг

(① ②) Зудын урьдчилсан мэдээ хүлээн авах, илгээхтэй холбоотой тулгарч буй асуудал
① Төсөөлж буй системийн бүтэц, технологийн шийдлийг нягталж, үр ашгийг нь дахин судлах
② Малчдаас авсан мэдээлэл зудын нөхцөл байдлыг шуурхай бөгөөд зөв урьдчилан тооцоход хэр үр ашигтай байхыг судлах
③ Малчид зуданд өртөхөөс зайлсхийхэд чиглэсэн дадал чадавхыг хэвшүүлэхэд зориулсан аппликэйшн боловсруулах ажил хэр үр ашигтай байхыг судлах
④ Малчдын интернет холболтын нөхцөл байдал, аппликэйшны ашиглалт хөгжүүлэлтийн аргачлалыг нягтлах

(③) Нарны эрчим хүчний систем нэвтрүүлэхтэй холбоотой тулгарч буй асуудал, үр дүн, тогтвортой байдлыг нягтлах
1. Зудаас шалтгаалан бөөнөөр нь мах бэлтгэх, махны үнэ унах, мах бэлтгэл болон тээвэрлэлтийн чанараас шалтгаалж үнэ буурах гэх зэрэг асуудлын талаарх мэдээлэл, үнэ унах механизмыг судалж, бодит нөхцөл байдлыг нягтлах
2. Нарны эрчим хүчний системийн ач холбогдол, үр ашгийг дахин нягталж ашиг, зардлын тооцоо гаргах
3. Нарны эрчим хүчний системийн Монгол дахь зах зээл болон үйлдвэрлэгч, борлуулагчийн талаар судлах, засвар үйлчилгээ байдаг эсэхийг судлах

(④) Малчдын мах бэлтгэлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх аргуудыг судлах
1. Малчдын бэлтгэдэг махтай холбоотой нөхцөл байдлыг задлан шинжлэх, тулгарч буй асуудлыг нягтлах (махны зохистой үнийг хадгалах гэх мэт)
2. Бүтээгдэхүүн мөшгөх системийг бий болгох, нэвтрүүлэх боломж
3. Мах нийлүүлэлтийн үеийн хөргөлтийн хэлхээний өнөөгийн байдал ба асуудлууд
4. Борлуулалтын шинэ гарцууд нээх, тулгарч буй асуудлууд

## Судалгааны үндсэн чиглэл

| | |
|---|---|
| **Үндсэн чиглэл 1: Цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох бодлогод нийцүүлсэн арга хэмжээ төлөвлөх** | |
| Судалгааны зорилго | Зудын эрсдэлийн мэдээ хүлээн авах, илгээх болон нарны эрчим хүч ашигласан хөргүүрийн системийг ашиглах нь зудын эрсдэлээс зайлсхийхэд малчдын аж ахуйг нь зохистойгоор өөрчлөхөд үр дүнтэй байгаа эсэхийг нягталж судлах. |
| Судалгааны аргачлал | • Хамрагдах аймаг (Дундговь аймаг, Говь-Алтай аймаг)-ийн малчдаас ярилцлага авах<br>• Ялангуяа, малчид өдөр тутамдаа зудын эрсдэлийн мэдээг хэрхэн ашиглаж байгаа талаар тодорхой болгох. |
| **Үндсэн чиглэл 2: Холбогдох байгууллагуудын уялдаа холбоо ба малчдын оролцооны идэвхийг дээшлүүлэх** | |
| Судалгааны зорилго | 1. Холбогдох төрийн байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээний талаар судлах.<br>2. Орон нутгийн хэрэгцээ шаардлагын талаар нарийвчилсан мэдээлэл цуглуулж, орон нутгийн засаг захиргаа болон малчдын төсөл дэх оролцоог хангах. |
| Судалгааны аргачлал | Воркшоп зохион байгуулах<br>① Нийслэл хотод холбогдох яам, агентлагуудыг оролцуулсан воркшоп зохион байгуулах.<br>② Судалгаанд хамрагдаж буй аймагт орон нутгийн засаг захиргаа болон малчдын төлөөллийг оролцуулсан воркшоп зохион байгуулах. (воркшопын оролцогч нарыг хэрхэн цуглуулах талаар аймгийн засаг захиргааны хариуцаж буй газар хэлтэстэй урьдчилан тохиролцож зохион байгуулах) |
| **Үндсэн чиглэл 3: Малын гаралтай бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээн дэх нарны эрчим хүч ашигласан хөргүүрийн системийн эзлэх байр суурийг тодорхой болгох** | |
| Судалгааны зорилго | 1. Махны зах зээлийн нийлүүлэлтийн асуудлыг тодорхой болгох (мөшгөх систем, хүнсний аюулгүй байдал, шинээр нь зах зээлд нийлүүлэх г.м.)<br>2. Нарны эрчим хүч ашигласан хөргүүрийн системийн нийлүүлэлтийн сүлжээнд эзэлж буй байр суурийг тодорхойлох. |
| Судалгааны аргачлал | Малын гаралтай бүтээгдэхүүний нийлүүлэлтийн үйл ажиллагаанд оролцож буй талууд (мах боловсруулах үйлдвэр, зуучлан борлуулагч, хүнсний зах болон тээврийн компани г.м.)-тай ярилцлага хийж мэдээлэл авах (орон нутгийн зөвлөх компаниар гүйцэтгүүлэх ажлууд багтсан). |
| **Үндсэн чиглэл 4: Эрдэмтэн судлаач нарын санал бодлыг авах** | |
| Судалгааны зорилго | Судалгааны үр дүнг бусад бүс нутагт нутагшуулах аргачлалын талаар судлах |
| Судалгааны аргачлал | Эрдэмтэн судлаач нарыг оролцуулсан хурал зохион байгуулах талаар судалж байгаа. |
| **Үндсэн чиглэл 5: Орон нутаг дахь судалгааны эрсдэлийн удирдлага** | |
| Судалгааны зорилго | Аюулгүй байдлыг хангаж судалгааны ажлыг гүйцэтгэх |
| Судалгааны аргачлал | Орон нутгийн хамаарал бүхий байгууллага болон этгээдтэй мэдээллийг зохистой хуваалцаж, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх |

# Ажлын график төлөвлөгөө (урьдчилсан байдлаар)



**Зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээ (цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээ) болон зудыг тэсвэрлэх чадавхыг бүрэлдүүлэх төслийн мэдээлэл цуглуулах судалгааны ажил**

—Дундговь аймагт хэрэгжүүлэх судалгааны ажлын төлөвлөгөө —

1 Зорилго
  1.1 Малчдынзудад тэсвэртэй, дасан зохицох арга хэмжээний талаар тодруулах
  1.2 Зудынурьдчилсан мэдээллийг хэрхэн ашиглаж байгаа нөхцөл байдлын талаар
  1.3 Мал, мах борлуулалттай холбоотой асуудлуудыг тодруулах

2 Судалгааг хэрэгжүүлэхарга
  2.1 Аймгийнзудын эсрэг арга хэмжээний өнөөгийн нөхцөл байдлыг тодруулах ба махны борлуулалт, зах зээлд нийлүүлэхтэй холбоотой асуудлыг аймгийн ХХААГ-ийн дарга болон Мал үржлийн албаны даргаас асууж тодруулах
  2.2 Малчдыноролцоотой уулзалт хэлэлцүүлэг (workshop) зохион байгуулах
    ① W/S -ийн оролцогчид: Сумын захиргаанаас оролцогч (10 хүн) сумын төвийн ойролцоох малчид (10 хүн), сумын төвөөс 10 км-ээс дээш зайтай амьдардаг малчид (30 хүн) нийт 50 хүн.
    ② Судалгаагхэрэгжүүлэх зорилтот 2 сумыг сонгох. 18-ны өдрийн уулзалтаар Гурвансайхан, Адаацаг сумыг сонголоо.
    ③ Сумын төвийн хурлын өрөөг ашиглах ба түүнийг зохицуулах, холбогдох хүмүүсийг цуглуулахыг сумын засаг дарга, мэргэжилтэн нараас хүсч байна.
  2.3 W/S зохион байгуулах байдал (санал)
    ① Малчин өрхөөс (10+20＝30 өрх) санал асуулгын хуудас бөглүүлж судалгаа авах (30мин).
    ② Нийт оролцогчдыг 5 бүлэгт хуваана. (10 хүн/малчин + 1сумын төвийн захиргааны албан хаагч)
  2.4 Бүлэг тус бүрээр доорхи сэдвээр хэлэлцэнэ. (60мин)
    (1) Зудын урьдчилсан мэдээллийг ямар байдлаар ашигладаг вэ?
    (2) Бэлчээр хамгаалахын тулд малын тоо толгойг бууруулах ямар арга хэмжээ авдаг вэ?
  2.5 Зорилтот 2 сумын дэд бүтэц, нөхцөл байдлын талаар тодруулж сумын ойролцоох малчидтай уулзаж ярилцах

3 Судалгаагхэрэгжүүлэх хугацаа
    ① Хэлэлцүүлэг зохион байгуулах өдөр
    10-р сарын 24-ний үдээс хойш хийх бодолтой байгаа ба судалгааны багийхан (Комияма, Уэхара, орчуулагч Хоролсүрэн) өглөө эрт Мандалговиос хөдөлж Адаацаг суманд ирэх ба12:30 цагт хэлэлцүүлэг хурлыг эхлүүлнэ.

4 Бусад

1. Өдрийн хоолны тухайд: Хэлэлцүүлэг хурал 3 цаг үргэлжлэхээр төлөвлөж байна. Үдээс хойш болохоор бол өдрийн хоол байхгүй. Хөнгөн жигнэмэг зэргийг бид бэлдэх бодолтой байна.
   10-р сарын 22,23-ны өдрүүдэд Гурвансайхан болон Адаацаг сумын ойролцоох малчид болон ялангуяа 2021 оны элсэн шуурганы эрсдэлд орсон малчин айлуудаар орох хүсэлтэй байгаа тул санал болгох малчин айлуудаар явна.
2. Эсвэл бид ажлын байдлаа харж байгаад 23-нд Адаацаг орж хоноод 24-ний үдээс өмнө воркшопоо хийх. Тэр тохиолдолд өдрийн хоол зохицуулах шаардлагатай болох ба төлбөр тооцоог бид хариуцна.
   Үдээс хойш бид Мандалговь буцах

Одоогийн байдлаар ийм хоёр хувилбар төлөвлөж байна.